

УСАНД ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СУДАЛГАА

*ДХИС-ийн “Ахлагч” мэргэжлийн боловсролын
сургуулийн Онцгой байдлын албаны тэнхимийн багш, хошууч
С.Мөнгөншагай*

Хураангуй: Усанд эрэн хайх, аврах ажиллагааны дадлага, сургалт, техник багаж хэрэгсэл, ур чадварын талаарх асуумж боловсруулан Монгол орны 21 аймгийг баруун, зүүн, хойд Улаанбаатар орчмын дөрвөн бүс гэж хувааж нийт 99 усчин аврагчдаас цахимаар судалгаа авч шаардлагатай арга хэмжээг тодорхойлоход чиглэгдсэн судалгааны ажил гэж үзэж байна.

Abstract: By developing a questionnaire about the the practice, training, equipment and skills of water search and rescue operations, 21 provinces of Mongolia were divided into four regions around Ulaanbaatar, west, east, and nort is.

Түлхүүр үг: Усчин аврагчдын сургалт, сэтгэл зүй, ур чадвар

Key words: Traning, psychology and skills of lifeguards

УДИРТГАЛ

Манай оронд байгалийн үзэгдэл, оршин буй газар зүйн тогтоцоос хамаарч, ган, зуд, үер ус, шороон болон цасан шуурга, ой хээрийн болон объектын түймэр, цөлжилт, хэт халалт, хүйтрэл зэрэг байгалийн гамшиг ихээхэн тохиолддог.

Усны ослын эрсдэлийг бууруулах судалгааны ажлын үр дүн” тайланд доктор, дэд хурандаа Ч.Мэндэлмаа (2021), **Монгол Улсын** хэмжээнд 2016-2021 оны хооронд эрэгтэй 488, эмэгтэй 39, нэг жилд дунджаар эрэгтэй 82, эмэгтэй найман хүн жил бүр усны ослоор нас барж байна гэсэн тоон судалгааг “Усны ослын эрсдэлийг бууруулах судалгааны ажил”-даа дурьдсан байна.


Дээрх байдлаас үзэхэд үер усны аюулын үед ажиллах Онцгой байдлын байгууллагын аврах анги, салбарын усчин аврагч нарыг бэлтгэх, аврах үйл ажиллагааг өргөжүүлэх нь бодит шаардлага бий болж байна.

Иймээс, стандартын дагуу мэргэжлийн усчин аврагчид усанд шумбах тоног төхөөрөмж, аврах багаж хэрэгсэл, усан доорх болон усны мандал дээрх ажлыг хангах хэрэгслийг ашиглан усанд эрэн хайх, аврах ажиллагааг хэрхэн хийж гүйцэтгэж байгаа байдлыг сонгон авч судлах нь судалгааны ажлын үндэслэл болсон.

Усанд эрэн хайх, аврах ажиллагаанд хийсэн судалгаа, түүний үр дүн


Монгол Улсын хэмжээнд сүүлийн зургаан жилд үер, усны ослын улмаас 625 хүн амь насаа алдаж /үүнээс 112 нь бага насны хүүхэд/ байна.

Сүүлийн зургаан жилд тохиолдсон гамшиг, ослоос аврагдсан хүний тоо болон түүнд амь насаа алдсан хүн амын судалгааг 1 дүгээр зургаар үзүүлэв.



Зураг 1. Нас барсан ба аварсан иргэдийн тоо

Сүүлийн зургаан жилд тохиолдсон усны ослоос аврагдсан хүн, түүнд амь насаа алдсан хүн амын судалгаанаас үзэхэд, жилд дунджаар 104 хүн амь насаа алдсан байна. Монгол оронд үер усны аюул ихээхэн тохиолдож түүнд иргэд амь насаа алдах явдал нэлээд тохиолдож байна.




Сүүлийн зургаан жилд гамшиг, аюулт үзэгдэл, ослоор амь насаа алдсан иргэдийн 43 хувь нь Коронавируст халдварт цар тахлаар /зөвхөн 2021 онд/, 29 хувь нь усны ослоор, 16 хувь нь объектын гал түймэрт өртсөн байна.

Зураг 2. Усны ослоор /сүүлийн 6 жил/ нас барсан хүмүүсийн судалгаа



Зураг 3. Эх сурвалж: Усны ослоор амь насаа алдсан хүмүүсийн шалтгаан нөхцөл байдлын судалгаа

Сүүлийн зургаан жилд үер, усны ослын шалтгаан их эзэлж байгаа бөгөөд нийт 368 тохиолдол буюу 625 хүн амралт, аялал зугаалгаар явж байхдаа амиа алдсан байна.




Усны ослын улмаас нас баралтын шалтгаан /сүүлийн зургаан жил/-ийг судалж зургаар харуулав.



Зураг 4. Усны ослоор амь насаа алдсан хүмүүсийн шалтгаан нөхцөл байдлын судалгаа

Дээрх судалгаанаас үер, усны ослын шалтгааныг судлан үзэхэд 625 хүн амь насаа алдсан байна. Тэдгээрийн 8,8 хувь буюу 51 хүн амралт зугаалгаар, 1,2 хувь буюу 8 хүн албан ажлаар, 17,9 хувь буюу 112 хүүхэд эцэг эхийн хараа хяналтаас гадуур үед, 9,7 хувь буюу 61 хүн гармаар гарах үед, 2,7 хувь буюу 17 хүн загасчлах ан агнах үед, 0,6 хувь буюу 4 хүн бусдыг уснаас аврах үед, 0,4 хувь буюу 3 хүн санаатайгаар амиа хорлолт, 2,4 хувь буюу 15 хүн усалгаа хийх үед, 0,1 хувь буюу 1 хүн завь осолдож, 1,7 хувь буюу 11 хүн тогтоол усанд, 3,8 хувь буюу 24 хүн мөс цөмрөх үед, 1,4 хувь буюу 9 хүн үерт, 6,4 хувь буюу 40 хүн архи уусан үед, 16,8 хувь буюу 105 хүн нь усанд сэлж байгаад, 24,4 хувь буюу 144 хүн шалтгаан нь тогтоогдоогүй байна.

Усны гүнд эрэн хайх аврах ажиллагаанд зарцуулсан цаг хугацааг 5 дугаар зургаар үзүүллээ.



Зураг 5. Усны гүнд эрэн хайх аврах ажиллагаанд зарцуулсан цаг хугацаа

Дээрх зургаас үзэхэд, усны гүнд эрэн хайх аврах ажиллагаанд зарцуулсан цаг хугацаагаар судалж үзэхэд 1-2 хоногт 51%, 3-7 хоногт 34%, 7-14 хоногт 11%, 14 хоногоос дээш 4% ноогдож байна. Нэрвэгдэгсдийг аврах үйл ажиллагаанд замын нөхцөл хол ойрын байдлаас ихээхэн нөлөөлж байгаа нь харагдаж байна.

Онцгой байдлын байгууллагын усчин аврагчдын уснаас эрэн хайх аврах ажиллагааны өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ:

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүйсийн ангилал

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Баруун бүс	14	14.1%	14.1%	14.1%
	Зүүн бүс	28	28.3%	28.3%	42.4%
	Улаанбаатар орчмын бүс	35	35.4%	35.4%	77.8%
	Хойд бүс	22	22.2%	22.2%	100%
	Нийт	99	100%	100%	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгаанд оролцож буй онцгой байдлын алба хаагчдын ажилладаг бүсийг 4 ангиллаар сонголт хийлгэн шинжиллээ. Шинжилгээг хэлбэлзлээр шалгахад, Баруун бүс 14 ба 14.1%, Зүүн бүс 28 ба 28.3%, Улаанбаатар хот орчмын бүс 35 ба 35.4%, Хойд бүс 22 ба 22.2% тус тус хамрагдсан байснаас, Улаанбаатар хот орчмын бүсийн алба хаагчид илүүтэй хамрагдсан гэж дүгнэж байна.

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын насны ангилал

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	18-23	12	12.12%	12.12%	12.1
	23.1-28	29	29.29%	29.29%	41.4
	28.1-33	27	27.27%	27.27%	68.7
	33.1-39	19	19.19%	19.19%	87.9
	39.1-45	10	10.10%	10.10%	98.00
	45 дээш	2	2.02%	2.02%	100.00
	НИЙТ	99	100.00%	100.00%	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгаанд оролцож буй онцгой байдлын алба хаагчдын насыг 6 ангилан оролцогч бүрийн сонголтод дүн шинжилгээ хийсэн.

Оролцогчдын хувьд, 18-23 настай 12 оролцогч ба 12.12%, 23.1-28 29 настай 29 оролцогч ба 29.29%, 28.1-33 настай 27 оролцогч ба 27.27%, 33.1-39 настай 19 оролцогч ба 19.19%, 39.1-45 настай 10 оролцогч ба 10.10% тус тус эзэлж байна. Эндээс, 23.1-28 настай оролцогчид хамгийн өндөр хувь эзэлж байсан бөгөөд онцгой байдлын албаны алба хаагчдын хувьд 23-28 настай залуучууд ажиллах хүчний нөөц болохыг баталлаа.

Хүснэгт 3. Оролцогчдын цогц асуумжийн үр дүн

№	ҮЗҮҮЛЭЛТ /асуумж/	Оролцогчдын тоо	Алдаа
1	Усанд эрэн хайх аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл хангалттай хүрэлцээтэй байдаг уу?	99	0
2	Мэргэжлийн тусгай сургалтын хөтөлбөрийн дагуу усан сангийн сургалтад хамрагдсан уу?	99	0
3	Ажиллагаанд бүрэн бүтэн байдал алдагдсан, гэмтэлтэй хувцас, тоног төхөөрөмжтэй оролцож байсан уу?	99	0
4	Уснаас эрэн хайх, аврах ажиллагаанд ашиглах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслээр бүрэн хангагдаж байна уу?	99	0
5	Уснаас эрэн хайх, аврах ажиллагааны журмын дагуу уснаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага, сургуулийг жилд 2 удаа зун, өвлийн нөхцөлд хээрийн гаралтаар 10-аас доошгүй хоногоор зохион байгуулдаг уу?	99	0
6	Уснаас эрэн хайх аврах ажиллагааны журмын дагуу аврагч усчин, шумбагч нар нь шумбалт гүйцэтгэхийн өмнө эмчийн үзлэгээр орж биеийн эрүүл мэндийн талаар дүгнэлт гаргуулдаг уу?	99	0

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжид “тийм” “үгүй” сонголттой нийт 6 асуултыг оруулж өгсөн. Үүнд:

- Усанд эрэн хайх аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийг багтаах хангалттай хүрэлцээтэй эсэх,
- Мэргэжлийн тусгай сургалтын хөтөлбөрийн дагуу усан сангийн сургалтад хамрагдсан эсэх,

- Ажиллагаанд бүрэн бүтэн байдал алдагдсан, гэмтэлтэй хувцас, тоног төхөөрөмжтэй оролцож байсан эсэх,
- Эрэн хайх, аврах ажиллагаанд ашиглах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслээр бүрэн хангагдаж байсан эсэх,
- Уснаас эрэн хайх, аврах ажиллагааны журмын дагуу уснаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага, сургуулийг жилд 2 удаа зун, өвлийн нөхцөлд хээрийн гаралтаар 10-аас доошгүй хоногоор зохион байгуулдаг байдал,
- Уснаас эрэн хайх аврах ажиллагааны журмын дагуу аврагч усчин, шумбагч нар нь шумбалт гүйцэтгэхийн өмнө эмчийн үзлэгээр орж биеийн эрүүл мэндийн талаар дүгнэлт гаргуулдаг эсэх

Дээрх 6 асуумжийн хүрээнд зөвхөн хоёр хариулттай авч нэгтгэн дүгнэж, харьцуулан шинжилсэн. Асуулт бүрд хариулсан оролцогчдын хариултыг дараах байдлаар харьцууллаа.

Хүснэгт 4. Усанд эрэн хайх аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл

Үзүүлэлт		Үнэлгээ	Frequency хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	25	25.25%	25.25%	Хүчинтэй тоон үзүүлэлт
	Үгүй	74	74.75%	74.75%	100%
	НИЙТ	99	100.00%	100.00%	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 01 асуулт “Усанд эрэн хайх аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл хангалттай хүрэлцээтэй байдаг уу?” асуултад нийт 99 оролцогчоос 25 оролцогч ба 25.25% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 74 ба 74.75% нь хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн байсан. Эндээс усанд эрэн хайх аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хангалттай хүрэлцээ бага гэж дүгнэх бүрэн боломжтой.

Хүснэгт 5. Мэргэжлийн тусгай сургалтын хөтөлбөрийн дагуу усан бассейны сургалтад хамрагдсан байдал

Үзүүлэлт		Үнэлгээ	Frequency хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	52	52.53%	52.53%	Хүчинтэй тоон үзүүлэлт
	Үгүй	47	47.47%	47.47%	100%
	НИЙТ	99	100%	100.00%	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 02 дахь асуулт “Мэргэжлийн тусгай сургалтын хөтөлбөрийн дагуу усан сангийн сургалтад хамрагдсан эсэх” асуултад нийт 99 оролцогчоос 52 оролцогч ба 52.53% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 47 ба 47.47% нь хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн байсан. Судалгаанаас үзэхэд аврагчдын Усан бассейнд усан сэлэтийн анхан ба дунд шатны сургалт, бэлтгэл хангалтгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 6. Ажиллагаанд бүрэн бүтэн байдал алдагдсан, гэмтэлтэй хувцас, тоног төхөөрөмжтэй оролцож байсан эсэх

Үзүүлэлт		Үнэлгээ	Frequency хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	56	56.57%	56.57%	Хүчинтэй тоон үзүүлэлт
	Үгүй	43	43.43%	47.47%	100%
	НИЙТ	99	100.00%	100.00%	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 03 дахь асуулт “Ажиллагаанд бүрэн бүтэн байдал алдагдсан, гэмтэлтэй хувцас, тоног төхөөрөмжтэй оролцож байсан эсэх” асуултад нийт 99 оролцогчоос 52 оролцогч ба 56.57% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 47 ба 47.47% нь хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн байсан.

Хүснэгт 7. Уснаас эрэн хайх, аврах ажиллагаанд ашиглах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслээр бүрэн хангагдаж байсан эсэх

Үзүүлэлт		Үнэлгээ	Frequency хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	30	30.30%	30.30%	Хүчинтэй тоон үзүүлэлт
	Үгүй	69	69.70%	69.70%	100%
	НИЙТ	99	100.00%	100.00%	

Тайлбар: Судалгааны SPSS 25. шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 4 дахь асуулт “Уснаас эрэн хайх, аврах ажиллагааны журмын дагуу уснаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага зохион байгуулдаг байдал” асуултад нийт 99 оролцогчоос 44 оролцогч ба 44.44% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 55 ба 55.56% нь

хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн байсан. Судалгаанаас үзэхэд усанд эрэн хайх аврах ажиллагааны дадлага сургалт дутмаг зохион байгуулагддаг нь харагдаж байна.

Хүснэгт 8. Уснаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага, сургалт зохион байгуулдаг байдал

Үзүүлэлт		Үнэлгээ	Frequency хэлбэлзэл	Percent Хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	44	44.44%	44.44%
	Үгүй	55	55.56%	55.56%
	НИЙТ	99	100.00%	100.00%

Тайлбар: Судалгааны SPSS 25.шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 5 дахь асуулт “Уснаас эрэн хайх, аврах ажиллагааны журмын дагуу уснаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага зохион байгуулдаг байдал” асуултад нийт 99 оролцогчоос 44 оролцогч ба 44.44% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 55 ба 55.56% нь хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн байсан. Судалгаанаас үзэхэд усанд эрэн хайх аврах ажиллагааны дадлага сургалт дутмаг зохион байгуулагддаг нь харагдаж байна.

Хүснэгт 9. Уснаас эрэн хайх аврах ажиллагаанд ороход эрүүл мэндийн талаар дүгнэлт гаргуулдаг байдал

Үзүүлэлт		Үнэлгээ	Frequency хэлбэлзэл	Percent Хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	48	48.48%	48.48%
	Үгүй	51	51.52%	51.52%
	НИЙТ	99	100.00%	100.00%

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 6 дахь асуулт “Уснаас эрэн хайх аврах ажиллагааны журмын дагуу аврагч усчин, шумбагч нар нь шумбалт гүйцэтгэхийн өмнө эмчийн үзлэгээр орж биеийн эрүүл мэндийн талаар дүгнэлт гаргуулдаг байдал ” асуултад нийт 99 оролцогчоос 48 оролцогч ба 48.48% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 51 ба 51.52% нь хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн байсан. Уснаас эрэн хайх аврах ажиллагаанд оролцоход аврагч нар эмчийн үзлэгт бага хамрагдаж байгааг судалгаанаас харуулж байна.

Хүснэгт 10.Алдаа

Оролцогчдын тоо	Хүчинтэй тоон үзүүлэлт	99
	Алдаа	0


Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Хүснэгт 11. Аврах ажиллагааны үед багаж хэрэгсэл гацах, биеийн байдалд ямар нэг өөрчлөлт орох үед ямар арга хэмжээ авдаг вэ?

Үзүүлэлт	Агуулга	Frequency хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Ажиллагааг үргэлжлүүлэх талаар шийдвэр гаргах	21	21.21%	21.21%
	Удирдлагын тушаал шийдвэрийг дагах	51	51.52%	51.52%
	Хэсэг амраад үргэлжлүүлэх	9	9.09%	9.09%
	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ авах	18	18.18%	18.18%
	НИЙТ	99	100.00%	100.00%

Уснаас эрэн хайх аврах ажиллагааны үед усчин, аврагчийн багаж хэрэгсэл эвдрэх, гацах, эрүүл мэндэд ямар нэгэн өөрчлөлт үүсэж мэдрэгдсэн үед аврах ажиллагааны зааварлагч буюу аврах ажиллагааны удирдагчид шууд мэдэгдэж аврах ажиллагааг шууд зогсох арга хэмжээ авна.

Зураг 6. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйл /дундаж утгын харьцуулалт/



Зураг 6. Дундаж утгын харьцуулалт
Хүснэгт 12. Техник тоног, төхөөрөмж

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйл				
Үзүүлэлт		Frequency хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Дундаж	1	1.01%	1.01%
	Чухал	38	38.38%	38.38%
	Маш чухал	60	60.61%	60.61%
	НИЙТ	99	100.00%	100.00%

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйлд техник тоног төхөөрөмж дундаж шаардлагатай 1 ба 1.01%, чухал шаардлагатай 38 ба 38.6%, маш чухал шаардлагатай 60 ба 60.61% хариулт өгсөн байна. Эндээс манай оролцогчдын ихэнх хувь болох 60 оролцогч нэн чухал шаардлагатай хариулт өгсөн тул гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд техник тоног төхөөрөмж маш чухал шаардлагатай гэж дүгнэх боломжтой.

Хүснэгт 13. Тусгай өрөө, орчин нөхцөл

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйл				
Үзүүлэлт		Frequency хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Чухал биш	2	2.02%	2.02%
	Дундаж	5	5.05%	5.05%
	Чухал	49	49.49%	49.49%
	Маш чухал	43	43.43%	43.43%
	НИЙТ	99	100.00%	100.00%

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйлд Тусгай өрөө, орчин нөхцөл хэрхэн шаардлагатай талаар судалгаанаас үзэхэд чухал биш 2 ба 2.02%, дундаж шаардлагатай 5 ба 5.05%, чухал шаардлагатай 49 ба 49.49%, маш чухал шаардлагатай 43 ба 43.43% нь

хариулт өгсөн байна. Эндээс манай оролцогчдын ихэнх хувь болох 92 оролцогч маш чухал буюу чухал шаардлагатай гэж хариулт өгсөн тул гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн, хойшлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагаанд оролцсон алба хаагчдад Тусгай өрөө, орчин нөхцөл хэрхэн хэрхэн шаардлагатай байгааг харуулж байна.

Хүснэгт 14. Эрх зүйн зохицуулалт

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйл				
Үзүүлэлт		Frequency хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Дундаж	1	1.01%	1.01%
	Чухал	57	57.58%	57.58%
	Маш чухал	41	41.41%	41.41%
	НИЙТ	99	100%	100%

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйлд эрх зүйн зохицуулалт дундаж шаардлагатай 1 ба 1.01%, чухал шаардлагатай 57 ба 57.58%, маш чухал шаардлагатай 41 ба 41.41% хариулт өгсөн байна. Эндээс манай оролцогчдын ихэнх хувь болох 57 оролцогч чухал шаардлагатай хариулт өгсөн тул гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд эрх зүйн зохицуулалт чухал шаардлагатай гэж дүгнэх боломжтой.

Хүснэгт 15. Холбогдох дүрэм

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйл				
Үзүүлэлт		Frequency хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Чухал	65	65.66%	65.66%
	Маш чухал	34	34.34%	34.34%
	НИЙТ	99	100%	100%

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйлд холбогдох дүрэм чухал шаардлагатай 65 ба 65.66%, маш чухал шаардлагатай 34 ба 34.34% хариулт өгсөн байна. Эндээс манай оролцогчдын ихэнх хувь болох 65 оролцогч нэн чухал шаардлагатай хариулт өгсөн тул гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд холбогдох дүрэм маш чухал шаардлагатай гэж дүгнэх боломжтой.

Хүснэгт 16. Холбогдох журам

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйл				
Үзүүлэлт		Frequency хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Дундаж	2	2.02%	2.02%
	Чухал	60	60.61%	60.61%
	Маш чухал	37	37.37%	37.37%
	НИЙТ	99	100%	100%

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйлд холбогдох журам дундаж шаардлагатай 2 ба 2.02%, чухал шаардлагатай 60 ба 60.61%, маш чухал шаардлагатай 37 ба 37.37% хариулт өгсөн байна. Эндээс манай оролцогчдын ихэнх хувь болох 60 оролцогч нэн чухал шаардлагатай хариулт өгсөн тул гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд холбогдох журам чухал шаардлагатай гэж дүгнэх боломжтой.

Хүснэгт 17. Байгууллага, агентлаг хоорондын хамтын ажиллагаа

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйл				
Үзүүлэлт		Frequency хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Дундаж	1	1.01%	1.01%
	Чухал	61	61.62%	61.62%
	Маш чухал	37	37.37%	37.37%
	НИЙТ	99	100.00%	100.00%

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйлд Байгууллага, агентлаг хоорондын хамтын ажиллагаа дундаж шаардлагатай 1 ба 1.01%, чухал шаардлагатай 61 ба 61.62%, маш чухал шаардлагатай 37 ба 37.37% хариулт өгсөн байна. Эндээс манай оролцогчдын ихэнх хувь болох 61 оролцогч нэн чухал шаардлагатай хариулт өгсөн тул гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд хамтын ажиллагаа чухал шаардлагатай гэж дүгнэх боломжтой.

Хүснэгт 18. Хувьсагчийн кодчлол

Техник тоног, төхөөрөмж	Тусгай өрөө, орчин нөхцөл	Эрх зүйн	Холбогдох дүрэм	Холбогдох журам	Байгууллага, агентлаг хоорондын хамтын ажиллагаа	Алба хаагчдад сэтгэл зүйн зөвлөгөө	Алба хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх сургалт
C1	C2	C3	C4	C5	C6	C7	C8

Хүснэгт 19. Хувьсагчдын хамаарлын шинжилгээ

№		C1	C2	C3	C4	C5	C6	C7	C8
C1	Pearson Correlation	1.000	0.051	0.277	0.489	0.349	0.219	0.085	0.236
	Sig. (2-tailed)		0.614	0.005	0.000	0.000	0.030	0.404	0.019
C2	Pearson Correlation	0.051	1.000	0.156	0.201	0.116	0.320	0.579	0.118
	Sig. (2-tailed)	0.614		0.124	0.046	0.254	0.001	0.000	0.243
C3	Pearson Correlation	0.277	0.156	1.000	0.552	0.452	0.176	0.210	0.347
	Sig. (2-tailed)	0.005	0.124		0.000	0.000	0.082	0.037	0.000
C4	Pearson Correlation	0.489	0.201	0.552	1.000	0.737	0.366	0.296	0.417
	Sig. (2-tailed)	0.000	0.046	0.000		0.000	0.000	0.003	0.000
C5	Pearson Correlation	0.349	0.116	0.452	0.737	1.000	0.477	0.234	0.471
	Sig. (2-tailed)	0.000	0.254	0.000	0.000		0.000	0.020	0.000

C6	Pearson Correlation	0.219	0.320	0.176	0.366	0.477	1.000	0.422	0.471
	Sig. (2-tailed)	0.030	0.001	0.082	0.000	0.000		0.000	0.000
C7	Pearson Correlation	0.085	0.579	0.210	0.296	0.234	0.422	1.000	1.186
	Sig. (2-tailed)	0.404	0.000	0.037	0.003	0.020	0.000		0.000
C8	Pearson Correlation	0.236	0.118	0.347	0.417	0.471	0.421	0.186	1.000
	Sig. (2-tailed)	0.019	0.243	0.000	0.000	0.000	0.000	0.065	
	**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).								
	*. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).								

Хүснэгт 20. Хувьсагчдын найдвартай байдлын шинжилгээ

Найдвартай байдлын утга	
Кронбах альфа	Нийт хувьсагчийн тоо
0.784	8

Дээрх нийт 8 асуумжийн найдвартай байдлыг Кронбах альфа утгаар шинжилсэн. Нийт асуулт бүрийн найдвартай байдлын нийлбэр 0.784 гарсан нь манай оролцогчдын хувьд асуулт бүрд үнэн бодитоор хариулсан, шинжилгээ бодит найдвартай байгааг баталлаа.

Хүснэгт 21. Хувьсагчдын хамаарлын нэгдсэн үр дүн

Найдвартай байдлын утга	
Кронбах альфа	Нийт хувьсагчийн тоо
0.729	17

Дээрх нийт 17 асуумжийн найдвартай байдлыг Кронбах альфа утгаар шинжилсэн. Нийт асуулт бүрийн найдвартай байдлын нийлбэр 0.729 гарсан нь манай оролцогчдын хувьд асуулт бүрд үнэн бодитоор хариулсан, шинжилгээ бодит найдвартай байгааг дахин баталлаа.

Судалгааны боловсруулалтыг SPSS-25.0 программ хангамжийг ашиглан хамаарлын шинжилгээ, хувьсагч бүрийн хэлбэлзлийн шинжилгээ, найдвартай байдлын шинжилгээг тус тус хийсэн болно.

Дүгнэлт

Сүүлийн зургаан жилд үер, усны ослын шалтгааныг судлан үзэхэд 625 хүн амь насаа алдсан байна. Тэдгээрийн 8,8 хувь буюу 51 хүн амралт зугаалгаар, 1,2 хувь буюу 8 хүн албан ажлаар, 17,9 хувь буюу 112 хүүхэд эцэг эхийн хараа хяналтаас гадуур үед, 9,7 хувь буюу 61 хүн гармаар гарах үед, 2,7

хувь буюу 17 хүн загасчлах ан агнах үед, 0,6 хувь буюу 4 хүн бусдыг уснаас аврах үед, 0,4 хувь буюу 3 хүн санаатайгаар амиа хорлолт, 2,4 хувь буюу 15 хүн усалгаа хийх үед, 0,1 хувь буюу 1 хүн завь осолдож, 1,7 хувь буюу 11 хүн тогтоол усанд, 3,8 хувь буюу 24 хүн мөс цөмрөх үед, 1,4 хувь буюу 9 хүн үерт, 6,4 хувь буюу 40 хүн архи уусан үед, 16,8 хувь буюу 105 хүн нь усанд сэлж байгаад, 24,4 хувь буюу 144 хүн шалтгаан нь тогтоогдоогүй байна.

Усчин аврагчийн үйл ажиллагаатай холбоотой цогц асуумжийн асуулт “Усанд эрэн хайх аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл хангалттай хүрэлцээтэй байдаг уу?” асуултад нийт 99 оролцогчоос 25 оролцогч ба 25.25% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 74 ба 74.75% нь хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн байсан. Эндээс усанд эрэн хайх аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хангалттай хүрэлцээ бага гэж дүгнэхэд хүрч байна.

Мөн “Мэргэжлийн тусгай сургалтын хөтөлбөрийн дагуу усан сангийн сургалтад хамрагдсан эсэх” асуултад нийт 99 оролцогчоос 52 оролцогч ба 52.53% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 47 ба 47.47% нь хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн байсан. Судалгаанаас үзэхэд аврагчдын Усан бассейнд усан сэлэлтийн анхан ба дунд шатны сургалт, бэлтгэл хангалтгүй байгааг харуулж байна.

“Уснаас эрэн хайх, аврах ажиллагаанд ашиглах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслээр бүрэн хангагдаж байсан эсэх?” асуултад нийт 99 оролцогчоос 30 оролцогч ба 30.30% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 69 ба 69.70% нь хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн байсан. Судалгаанаас үзэхэд усанд эрэн хайх аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хуурай, нойтон хувцасны иж бүрдэл дутмаг байгааг харуулж байна.

“Уснаас эрэн хайх, аврах ажиллагааны журмын дагуу уснаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага зохион байгуулдаг байдал” асуултад нийт 99 оролцогчоос 44 оролцогч ба 44.44% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 55 ба 55.56% нь хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн байсан. Судалгаанаас үзэхэд усанд эрэн хайх аврах ажиллагааны дадлага сургалт дутмаг зохион байгуулагддаг нь харагдаж байна.

“Уснаас эрэн хайх аврах ажиллагааны журмын дагуу аврагч усчин, шумбагч нар нь шумбалт гүйцэтгэхийн өмнө эмчийн үзлэгээр орж биеийн эрүүл мэндийн талаар дүгнэлт гаргуулдаг байдал” асуултад нийт 99 оролцогчоос 48 оролцогч ба 48.48% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн

бол 51 ба 51.52% нь хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн байсан. Уснаас эрэн хайх аврах ажиллагаанд оролцоход аврагч нар эмчийн үзлэгт бага хамрагдаж байгааг судалгаанаас харуулж байна

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйлд техник тоног төхөөрөмж дундаж шаардлагатай 1 ба 1.01%, чухал шаардлагатай 38 ба 38.6%, маш чухал шаардлагатай 60 ба 60.61% хариулт өгсөн байна. Эндээс манай оролцогчдын ихэнх хувь болох 60 оролцогч нэн чухал шаардлагатай хариулт өгсөн тул гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд техник тоног төхөөрөмж маш чухал шаардлагатай гэж дүгнэх боломжтой.

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай зүйлд эрх зүйн зохицуулалт дундаж шаардлагатай 1 ба 1.01%, чухал шаардлагатай 57 ба 57.58%, маш чухал шаардлагатай 41 ба 41.41% хариулт өгсөн байна. Эндээс манай оролцогчдын ихэнх хувь болох 57 оролцогч чухал шаардлагатай хариулт өгсөн тул гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд эрх зүйн зохицуулалт чухал шаардлагатай гэж дүгнэх боломжтой.

ЭХ СУРВАЛЖ

1. Гамшигтай тэмцэх үндэсний чадавхыг бий болгохын төлөө, НҮБ, Гамшгийн аюулыг бууруулах олон улсын стратегийн газар, 2007
2. Болдбаатар.Ш, Гамшгийн менежмент, УБ., 2003
3. Баяржаргал.Б, Гамшгийн төрөл бүрээр эрсдэлийн үнэлгээ хийх арга зүй УБ., 2016
4. Ганболд.Б, Усанд эрэн хайх, аврах үйл ажиллагааны онцлог, УБ., 2020
5. Дамдин.П, Гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент УБ., 1989
6. Монгол Улсын гамшгийн удирдлагын шинэчлэлт, МОН/02/305 төсөл, УБ., 2004
7. Онцгой байдлын үеийн гарын авлага, НҮБ-ын Дүрвэгсдийн дээд комиссарын газар, Женев, 2007
8. Паламдорж.Ш, Цэдэв.П, нарын.,Гамшгийн эрсдэлийг үнэлэх арга зүй УБ., 2010
9. Төмөр. Х, Аврагчийн лавлах 1. 2, УБ., 1997
10. Төрөөс Гамшигаас хамгаалах талаар баримтлах бодлого, үндэсний хөтөлбөр, Үндэсний бага хурлын эмхтгэл, УБ., 2011
11. Үржин.О, Цэдэв.П, нарын., Эрэн хайх аврах ажлын үндэс, УБ.
12. Үржин.О, Цэдэв.П, нарын Аюулгүй амьдрах ухааны үндэс I.П.Ш гарын авлага
13. Үржин.О, Гамшгийн менежмент дэд дэвтэр, УБ., 2004
14. Үржин.О Цэдэв.П нарын Гамшгаас хамгаалах үндэс УБ., 2017